

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ 2 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2016 оны нэгдүгээр сарын 26-ны 10 цаг 12 минутад эхэлж, 12 цаг 25 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн даргын өрөөнд болж, нийт 2 цаг 13 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Салбар зөвлөлийн 2015 оны хурлын шийдвэрийн хэрэгжилтийн тайлангийн тухай	Албан тоотын хариу ирүүлэхгүй байгаа сум, байгууллагын тоотын хариуг хугацаанд нь ирүүлэх асуудлыг хариуцсан гишүүдэд нь даалгав.
2	Салбар зөвлөлийн 2016 оны жилийн төлөвлөгөө батлах тухай	Салбар зөвлөлийн 2016 оны төлөвлөгөөнд гишүүдээс гарсан саналыг нэмж тусган батлахаар шийдвэрлэв.
3	Төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох, ахиулах тухай	Нэр бүхий 58 төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушалын зохих зэрэг дэвийг шинээр олгох , ахиулах асуудлыг аймгийн Засаг даргад санал болгон уламжлах тогтоол гаргахаар шийдвэрлэв.
4	Нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн сул орон тооны захиалгын тухай нөөцөд бүртгүүлсэн иргэдийг нэр дэвшүүлэх тухай	Дундговь аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд бүртгүүлсэн иргэдээс тус аймгийн Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн жагсаалтад 2015 оны 08 дугаар сарын 10-ны өдөр бүртгэгдсэн Эрдэнэ овогтой Уянгыг томилуулахаар нэр дэвшүүлэхээр шийдвэрлэв.
5	Цагаандэлгэр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Сайнцагаан сумын ЗДТГ-ын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байранд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Цагаандэлгэр сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд тухайн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад 60,08 оноогоор тэнцэж, аймгийн ТАСЗ-ийн 2015 оны 04 дүгээр сарын 13-ны 15 дугаар тогтоолоор удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Эрдэнэ-Очир овогтой Сугармааг нэр дэвшүүлэхээр шийдвэрлэснийг, санал дүгнэлтийн хамт хүргүүлэх, Сайнцагаан сумын Байгаль орчны байцаагчийн албан тушаалд тус аймгийн Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтанд 70,33 оноо авч, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 196 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Жамбалдорж овогтой Миеэсүрэнг томилуулахаар нэр дэвшүүлэхээр тус тус шийдвэрлэв.
6	Нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн сул орон тооны захиалгад мэргэшлийн шалгалт зарлуулах тухай.	Нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн дэс түшмэлийн 7, туслах түшмэлийн 5 хийт 12 ажлын байранд мэргэшлийн шалгалт зарлуулахаар Төв комисст хүргүүлэхээр шийдвэрлэв..

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА